



**Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо**

ИВЭЭН ТЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮМҮҮСТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

2026 ОНЫ 03 САРЫН 13-НЫ
ӨДРӨӨС ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛНЭ



ИВЭЭН ТЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮМҮҮСТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь усан спортыг хөгжүүлэх, холбооны үйл ажиллагаа, тэмцээн уралдаан, сургалт, төсөл хөтөлбөрийг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор ивээн тэтгэгч байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журмаар ивээн тэтгэгч татах, хамтын ажиллагааг зохион байгуулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хянах, ивээн тэтгэгч олж зуучилсан этгээдийг урамшуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.3 Хамтын ажиллагаанд ил тод, харилцан ашигтай, хууль тогтоомжид нийцсэн, ёс зүйтэй байх зарчмыг баримтална.

Хоёр. НЭР ТОМЬЁО

2.1 "Ивээн тэтгэгч" гэж холбооны үйл ажиллагаанд санхүүгийн болон эд материалын дэмжлэг үзүүлж буй байгууллага, хувь хүнийг ойлгоно.

2.2 "Хамтын ажиллагаа" гэж тэмцээн уралдаан, төсөл, хөтөлбөр, сургалт болон бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сурталчилгаа хийх, нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах үйл ажиллагааг ойлгоно.

2.3 "Зуучлагч" гэж ивээн тэтгэгчийг олж, холбоотой хамтын ажиллагаа эхлүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гурав. ИВЭЭН ТЭТГЭГЧТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ХЭЛБЭР

3.1 Хамтын ажиллагаа дараах хэлбэртэй байж болно:

3.1.1 Тэмцээн уралдаан ивээн тэтгэх

3.1.2 Тамирчин, багийн бэлтгэл, сургалтыг дэмжих

3.1.3 Тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх

3.1.4 Нийгмийн болон сурталчилгааны хамтарсан арга хэмжээ зохион байгуулах

3.1.5 Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх



3.2 Хамтын ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

Дөрөв. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

4.1 Ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах саналыг холбогдох зөвлөл, албан тушаалтан судалж танилцуулна.

4.2 Гэрээнд дараах үндсэн нөхцөлүүдийг тусгана:

4.2.1 Дэмжлэгийн хэлбэр, хэмжээ

4.2.2 Хугацаа

4.2.3 Талуудын эрх, үүрэг

4.2.4 Сурталчилгаа, нэр хүндтэй холбоотой зохицуулалт

4.3 Гэрээг холбооны эрх бүхий албан тушаалтан байгуулна.

Тав. ИВЭЭН ТЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Ивээн тэтгэгч дараах эрхтэй:

5.1.1 Гэрээнд заасан хэмжээнд нэр, брэндээ сурталчлуулах

5.1.2 Дэмжлэгийн зориулалт, хэрэгжилтийн мэдээлэл авах

5.2 Ивээн тэтгэгч дараах үүрэгтэй:

5.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх

5.2.2 Холбооны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх

Зургаа. ИВЭЭН ТЭТГЭГЧ ОЛЖ ЗУУЧИЛСАН ХУВЬ ХҮН,

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ УРАМШУУЛАХ

6.1 Ивээн тэтгэгчийг шинээр олж, хамтын ажиллагааг эхлүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан хувь хүн, хуулийн этгээдийг урамшуулж болно.

6.2 Энэхүү журам нь зөвхөн холбооны гишүүн хувь хүн, дасгалжуулагч, шүүгч, тамирчин болон холбооны гишүүн байгууллагын албан тушаалтанд үйлчилнэ.



6.3 Холбооноос албан ёсны үндсэн цалин, тогтмол урамшуулал авдаг албан хаагчид журмын 6-р зүйлийн үйлчлэлд хамаарахгүй.

6.4 Олон улсын байгууллага, холбоодоос олгосон аливаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт журмын 6-р зүйлийн үйлчлэлд хамаарахгүй.

6.5 Ивээн тэтгэгчийг олж зуучилсан этгээдэд тухайн ивээн тэтгэлгийн холбооны дансанд бодитоор орсон дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал олгоно.

6.6 Урамшуулал олгох нөхцөл:

6.6.1 Ивээн тэтгэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болсон байх

6.6.2 Санхүүгийн дэмжлэг бодитоор шилжин орсон байх

6.6.3 Зуучлагчийн оролцоо бодит байх

6.7 Нэг ивээн тэтгэгчийг хэд хэдэн этгээд хамтран зуучилсан тохиолдолд урамшууллыг оролцооны хэмжээг харгалзан хуваарилж болно.

6.8 Урамшуулал олгох шийдвэрийг доорхи баримтуудад үндэслэн Ерөнхий нарийн бичгийн дарга гаргана.

6.8.1 Ивээн тэтгэгчтэй холбогдсон талаархи танилцуулга

6.8.2 Гэрээ, хэлцлийн хуулбар

6.8.3 Санхүүгийн шилжүүлгийн баримт

6.9 Холбооноос урамшуулал олгосон тухай мэдээллийг Удирдах зөвлөлд танилцуулна.

6.10 Батлагдсан урамшууллыг санхүүгийн журамд нийцүүлэн олгоно.

Долоо. БАРИМТ БҮРДҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

7.1 Ивээн тэтгэгчтэй холбоотой бүх гэрээ, санхүүгийн баримтыг холбогдох албан тушаалтан бүртгэж хадгална.

7.2 Хамтын ажиллагааны хэрэгжилтэд холбогдох зөвлөл, албан тушаалтан хяналт тавина.

Найм. БУСАД ЗҮЙЛ

8.1 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

8.2 Журамд өөрчлөлт оруулах асуудлыг Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.3 Журмыг хэрэгжүүлэхдээ ил тод байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

